

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Соёлын төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/146/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelqerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99389927 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Гурван Хөх Морьт Аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг
Утас: 99051815 Цахим хаяг: gurvankhukhmoritlc@gmail.com
Аудитор: Д.Соёлсайхан
Утас: 91929196 Цахим хаяг: gurvankhukhmoritlc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/287
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
Б.АЛТАНХАРГАНА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Соёлын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Соёлын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын засаг даргын захирамжаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 19,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналтын горим сорил хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал илрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Тус төвийн дарга нь Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын засаг даргатай 2024 онд хэрэгжүүлж ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан 77.0 хувийн ажлын гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

6720021803

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,888,482.65	22,034,179.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,144,462.65	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,144,462.65	-
3121	Төгрөг	15,144,462.65	-
31211	Төрийн сангийн харилцах	15,144,462.65	-
35	БАРАА МАТЕРИАЛ	20,744,020.00	22,034,179.40
354	Хангамжийн материал	20,744,020.00	22,034,179.40
35410	Бичиг хэргийн материал	250,000.00	437,000.00
35420	Аж ахуйн материал	15,200,270.00	16,797,170.00
35440	Түлш, шатах тослох материал	5,293,750.00	4,800,009.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	98,911,771.04	119,873,551.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	98,911,771.04	119,873,551.75
392	Биет хөрөнгө	93,643,771.08	114,937,551.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	108,605,588.00	108,605,588.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(43,746,044.40)	(52,176,458.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	63,755,284.08	93,215,674.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,258,621.12)	(53,063,751.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,822,987.50	7,325,787.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,250,648.98)	(1,683,514.31)
39217	Ном	11,715,226.00	12,714,226.00
393	Биет бус хөрөнгө	5,267,999.96	4,935,999.92
39301	Програм хангамж	1,630,000.00	1,630,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(392,000.04)	(718,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,030,000.00	4,030,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	134,800,253.69	141,907,731.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	134,800,253.69	141,907,731.15
51	Засгийн газрын хувь оролцоо	134,800,253.69	141,907,731.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	118,338,469.00	118,338,469.00
51101	Өмч: - төрийн	118,338,469.00	118,338,469.00
512	Хуримтлагдсан үр дүн	(28,619,003.31)	(21,511,525.85)
51210	Өмнөх үеийн үр дүн	(42,178,859.40)	(28,619,003.31)
51220	Тайлант үеийн үр дүн	13,559,856.09	7,107,477.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,080,788.00	45,080,788.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	134,800,253.69	141,907,731.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	210,824,888.67	394,149,108.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,494,987.50	30,111,190.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,494,987.50	30,111,190.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,494,987.50	30,111,190.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,893,000.00	1,809,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	740,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,861,987.50	28,301,690.00

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,329,901.17	364,037,918.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	181,088,701.17	285,507,918.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	181,088,701.17	285,507,918.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,241,200.00	78,530,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,241,200.00	78,530,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	197,265,032.58	384,798,831.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	197,265,032.58	384,798,831.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	161,989,384.03	263,764,118.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,063,938.84	172,224,133.82
210101	Үндсэн цалин	83,799,422.92	111,700,040.11
210102	Нэмэгдэл	11,819,825.02	46,042,693.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,080,000.00	-
210104	Урамшуулал	11,364,690.90	14,481,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,772,400.00	28,416,900.00
210201	Тэтгэврийн даатгал	10,817,900.00	19,323,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,238,600.00	2,273,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	991,300.00	1,136,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	247,400.00	1,136,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,477,200.00	4,546,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,344,741.45	7,625,535.23
210301	Гэрэл, цахилгаан	1,044,741.45	881,785.23
210302	Түлш, халаалт	-	6,743,750.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	17,782,427.48	10,619,890.60
210401	Бичиг хэрэг	446,600.00	483,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,381,904.80	5,949,990.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	445,322.68	1,450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,508,600.00	2,736,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	789,000.00	16,452,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	6,095,400.00
210604	Урсгал засвар	789,000.00	10,356,950.00
2107	Томилолт, зочны зардал	299,500.00	1,260,000.00
210702	Дотоод албан томилолт	299,500.00	1,260,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,133,900.00	9,989,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,583,900.00	7,915,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	510,000.00	1,900,000.00
210807	Газрын төлбөр	40,000.00	24,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,803,476.26	17,176,309.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	913,057.00	5,175,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,890,419.26	12,000,409.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,275,648.55	121,034,712.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,440,390.00	1,935,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,542,000.00	1,158,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,305,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,892,790.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	776,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	70,870,247.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	70,870,247.53
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,835,258.55	48,228,864.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,835,258.55	48,228,864.77

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,559,856.09	9,350,277.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,242,800.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	2,242,800.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,242,800.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,559,856.09	7,107,477.46

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	118,338,469.00	45,080,788.00	(42,178,859.40)	121,240,397.60
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,338,469.00	45,080,788.00	(42,178,859.40)	121,240,397.60
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	13,559,856.09	13,559,856.09
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,338,469.00	45,080,788.00	(28,619,003.31)	134,800,253.69
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	118,338,469.00	45,080,788.00	(28,619,003.31)	134,800,253.69
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,338,469.00	45,080,788.00	(28,619,003.31)	134,800,253.69
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	7,107,477.46	7,107,477.46
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,338,469.00	45,080,788.00	(21,511,525.85)	141,907,731.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	206,962,901.17	365,847,418.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,633,000.00	1,809,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,633,000.00	1,809,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,633,000.00	1,809,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,893,000.00	1,809,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	740,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,329,901.17	364,037,918.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	181,088,701.17	285,507,918.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	181,088,701.17	285,507,918.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,241,200.00	78,530,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,241,200.00	78,530,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	191,822,438.52	376,331,381.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,822,438.52	376,331,381.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,546,789.97	255,296,669.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,063,938.84	172,224,133.82
210101	Үндсэн цалин	83,799,422.92	111,700,040.11

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	11,819,825.02	46,042,693.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,080,000.00	-
210104	Урамшуулал	11,364,690.90	14,481,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,772,400.00	28,416,900.00
210201	Тэтгэврийн даатгал	10,817,900.00	19,323,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,238,600.00	2,273,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	991,300.00	1,136,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	247,400.00	1,136,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,477,200.00	4,546,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,099,741.45	12,301,785.23
210301	Гэрэл, цахилгаан	1,044,741.45	881,785.23
210302	Түлш, халаалт	5,705,000.00	10,640,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,350,000.00	780,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,370,322.68	4,850,000.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	600,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,085,000.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	535,322.68	1,450,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	450,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	-	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,418,100.00	22,415,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,111,900.00	4,928,000.00
210604	Урсгал засвар	7,306,200.00	17,487,850.00
2107	Томилолт, зочны зардал	299,500.00	1,260,000.00
210702	Дотоод албан томилолт	299,500.00	1,260,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,428,900.00	10,333,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,878,900.00	8,259,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	510,000.00	1,900,000.00
210807	Газрын төлбөр	40,000.00	24,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,093,887.00	2,995,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,093,887.00	2,995,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,275,648.55	121,034,712.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,440,390.00	1,935,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,542,000.00	1,158,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,305,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,892,790.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	776,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	70,870,247.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	70,870,247.53
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,835,258.55	48,228,864.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,835,258.55	48,228,864.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,140,462.65	(10,483,962.65)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,660,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,660,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,660,500.00

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	4,660,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(4,660,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	15,140,462.65	(15,144,462.65)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,000.00	15,144,462.65
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,144,462.65	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	287,368,500.00	231,642,633.82	55,725,866.18	80.61%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,368,500.00	231,642,633.82	55,725,866.18	80.61%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,429,700.00	229,707,033.82	55,722,666.18	80.48%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,334,800.00	172,224,133.82	55,110,666.18	75.75%
210101	Үндсэн цалин	136,682,100.00	111,700,040.11	24,982,059.89	81.72%
210102	Нэмэгдэл	72,660,900.00	46,042,693.71	26,618,206.29	63.36%
210104	Урамшуулал	17,991,800.00	14,481,400.00	3,510,400.00	80.49%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,416,900.00	28,416,900.00		100.0%
210201	Тэтгэврийн даатгал	19,323,500.00	19,323,500.00		100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	2,273,300.00	2,273,300.00		100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,136,700.00	1,136,700.00		100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,136,700.00	1,136,700.00		100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,546,700.00	4,546,700.00		100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	5,900,000.00	5,849,000.00	51,000.00	99.13%
210401	Бичиг хэрэг	600,000.00	600,000.00		100.0%
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00		100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,450,000.00	50,000.00	96.66%
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	999,000.00	1,000.00	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	500,000.00		100.1%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00		100.0%
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00		100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00		100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,090,000.00	8,078,000.00	12,000.00	99.85%
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,090,000.00	8,078,000.00	12,000.00	99.85%
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	1,260,000.00	40,000.00	99.73%
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	1,260,000.00	40,000.00	99.73%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,827,500.00	10,384,000.00	443,500.00	95.43%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,317,500.00	8,310,000.00	7,500.00	99.29%

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00	-	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,320,000.00	1,900,000.00	420,000.00	81.89%
210807	Газрын төлбөр	40,000.00	24,000.00	16,000.00	60.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,060,500.00	2,995,000.00	65,500.00	99.8%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,060,500.00	2,995,000.00	65,500.00	99.8%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,938,800.00	1,935,600.00	3,200.00	99.58%
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,938,800.00	1,935,600.00	3,200.00	99.58%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,158,800.00	1,158,800.00	-	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	776,800.00	3,200.00	99.58%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	287,368,500.00	231,642,633.82	55,725,866.18	98.91%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	285,508,000.00	229,847,633.82	55,660,336.18	80.50%
131001	Улсын төсвөөс санхүүжих	285,508,000.00	229,847,633.82	55,660,336.18	80.50%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,860,500.00	1,795,000.00	65,500.00	105.2%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,860,500.00	1,795,000.00	65,500.00	105.2%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	-	100.0%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0%
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	10	10	-	100.0%
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	5	5	-	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0%
620004	Гэрээт ажилтан	3	3	-	100.0%

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутаг/

/Төгрөгөөр/					
	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүнгээр	Хувь%
71702	Соёл урлаг	78,530,000.00	30,301,135.23	48,228,864.77	38.59
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	78,530,000.00	30,301,135.23	48,228,864.77	38.59
12	Татварын бус орлого	78,530,000.00	78,530,000.00	-	100.00
12200	Тусламжийн орлого	78,530,000.00	78,530,000.00	-	100.00
122005	Төсвөөс санхүүжих	78,530,000.00	78,530,000.00	-	100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,530,000.00	30,301,135.23	48,228,864.77	38.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,530,000.00	30,301,135.23	48,228,864.77	38.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,530,000.00	30,301,135.23	48,228,864.77	38.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,530,000.00	12,301,785.23	48,228,214.77	20.32
210301	Гэрэл, цахилгаан	7,750,000.00	881,785.23	6,868,214.77	11.38
210302	Түлш, халаалт	52,000,000.00	10,640,000.00	41,360,000.00	20.46

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,000,000.00	17,999,350.00	650.00	100.00
210604	Урсгал засвар	18,000,000.00	17,999,350.00	650.00	100.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,904.1 мянган төгрөгийн 9 зөрчил илрүүлж, 3,053.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх 2 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илүү цагийн цалин

Илрүүлэлт: Тус соёлын төвийн дарга өөртөө илүү цагийн хөлсийг заасан хэмжээнээс хэтрүүлэн 680.9 мянган төгрөгийг бодож олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна." гэж заасантай нийцээгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Балансын урамшуулал

Илрүүлэлт: Соёлын төвийн даргын 2024 оны Б/16 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно." гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогчоос тусдаа нэр бүхий 7 албан хаагчдад 2,372.2 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно." гэх нийцээгүй бай "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Багаж, техник хэрэгслийн зардал

Илрүүлэлт: Байгууллагын эзэмшилд авто машин бүртгэлгүй бөгөөд багаж, техник хэрэгслийн зардлаас 771.0 мянган төгрөгийн автомашины сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй ба "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага өгөв.

5.2.2 Тээвэр шатахууны зардал

Илрүүлэлт: Анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заалтуудтай нийцээгүй ба "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

5.3.1 Анхан шатны баримтын бүрдэл

Илрүүлэлт: Урлагийн наадмын шагналыг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн гэх анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажил гүйлгээг бүртгэж ажиллах

5.3.2 Тооллогын бүртгэл

Илрүүлэлт: Хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллого хийсэн илтгэх хуудас байхгүй, тооцоо бодсон акт байхгүй, эд хариуцагчдын картад гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалттай нийцээгүй ба "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалыг бэлтгэн ажиллах

5.3.3 Зардлын эдийн засгийн ангилал

Илрүүлэлт: Цэвэр, бохир усны зардлаас 780.0 мянган төгрөгийн шугам хоолойны засварын материал, багаж техник хэрэгслийн зардлаас 500.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-г дагаж мөрдөөгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах

5.3.4 Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Илрүүлэлт: Тайлант хугацаанд нийт оруулбал зохих 171 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, холбогдох тушаал шийдвэрийг хавсралт файлаар оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэх заалт, 6 дугаар зүйлийн 6.3.3-т "төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар;"-г мөрдөж ажиллаагүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн, хуулийн хугацаанд байршуулж байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус соёлын төвийн дарга өөртөө илүү цагийн хөлсийг заасан хэмжээнээс хэтрүүлэн 680.9 мянган төгрөгийг бодож олгосон байна.	1	680.9	1	680.9				
Соёлын төвийн даргын 2024 оны Б/16 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно." гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогчоос тусдаа нэр бүхий 7 албан хаагчдад балансын урамшуулал олгосон байна.	1	2,372.2		2,372.2		-		-
Байгууллагын эзэмшилд авто тээврийн хэрэгсэл байхгүй байхад багаж техник хэрэгслийн зардлаас 771.0 мянган төгрөгийн автомашины сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна.	1	771.0		-	1	771.0		-
Анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан байна.	1	1,800.0			1	1,800.0		-
Урлагийн наадмын шагналыг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн нь анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	1	-					1	-
Хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллого хийсэн илтгэх хуудас байхгүй, тооцоо бодсон акт байхгүй, эд хариуцагчдын картад гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.	1						1	-
Цэвэр, бохир усны зардлаас 780.0 мянган төгрөгийн шугам хоолойны засварын материал, багаж техник хэрэгслийн зардлаас 500.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан байна.	1	1,280.0					1	12800
Дүн	7	6,904.1	2	3,053.1	2	2,571.0	3	1,280.0

Санхүүгийн тайлангийн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс
--------------------	-------------	--------

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тайланд төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, холбогдох тушаал шийдвэрийг хавсралт файлаар оруулдаггүй.	1	-					1	-
Дүн	1	-					1	-